ХОРИО ЦЭЭРИЙН ХЭЛТСИЙН ЭРҮҮЛ АХУЙ ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТ ХАРИУЦСАН
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Ц.ОТГОНБОРЫН 2024 ОНЫ
**ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2024.12.09

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2023 он/ | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхэлсэн, дуусан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангасан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. Гаалийн газар, хороодын эрүүл ахуйн халдвар хамгааллын хяналтын чиглэл хариуцсан гаалийн улсын байцаагчдаас улсын хилээр нэвтэрч буй зорчигчдод тавигдах хяналт тандалтын мэдээг нэгтгэн, газрын болон хэлтсийн удирдлага, холбогдох газруудыг мэдээллээр хангаж ажиллаж байна.<br>- Улсын хилээр орсон 524101 (дотоод 413740, гадаад 57214), улсын хилээр гарсан 522041 (дотоод 413740, гадаад 110361) зорчигч, жолоочид эрүүл мэндийн хяналт тандалт хийж, хилээр нэвтрүүлэхэд халдварт өвчтэй, халдварын сэжигтэй зорчигч нэвтрүүлээгүй байна. | 1.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал /хүний хөл хориот өвчин/-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангана.<br><br>2. Улсын хилээр нэвтэрч буй зорчигчдод тавигдаж буй хяналт тандалтын мэдээг сар бүр нэгтгэн удирдлага, холбогдох газруудад хүргүүлнэ.<br><br>3."Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг хуудас"-д нэмэлт өөрчлөлт оруулах | 1.Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалаар батлагдсан Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал /хүний хөл хориот өвчин/-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр гаалийн газар, хороодод чиглэл өгч, хариу арга хэмжээг авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллав.<br>2. Улсын хилээр орсон 3922826 (дотоод 2925086, гадаад 997740), улсын хилээр гарсан 2688090 (дотоод 1892250 гадаад 795840) зорчигч, жолоочид эрүүл мэндийн хяналт тандалт хийж, хилээр нэвтрүүлэхэд халдварт өвчтэй, халдварын сэжигтэй зорчигч нэвтрүүлээгүй байна.<br>3. ГЕГ-ын даргын 2024.08.22-ны өдрийн А/452 дугаартай "Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг хуудасны загварыг батлах тухай" тушаалын хавсралтаар "Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг" хуудсыг батлуулж, цаасан | 2024.01.01<br>2024.12.10 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2. Халдвараас урьдчилан сэргийлэх, сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>3. Гаалийн хорио цээрийн газраас "Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг хуудсыг цахимжуулах" үйл ажиллагааг Гэрэгэ системс ХХК-тай хамтран гар утаст суурилсан "Arrive mn" аппликашионыг нэвтрүүлж, Замын-Үүд автозамыг боомтоор хил нэвтрүүлж буй зорчигчдоор бөглүүлэн хэвшүүлж, зарим боомтод турших байна. | | хэлбэрээр ашиглахад шаардлагатай тоо, хэмжээний захиалгыг нэгтгэн нийт 50.000 ширхэгийг хэвлүүлэх хүсэлтийг СХОГ-т гаргаж, Алтанбулаг, ЧХОУНБ дахь гаалийн газруудад ЗЭММ хуудас хэвлүүлэхээр нийт 3 сая төгрөгийг шийдвэрлүүлж, бэлэн байдлыг ханган ажилласан.<br>4.УОК-ын даргын 07 дугаартай тушаалаар "Шуурхай бүлгийн бүрэлдэхүүн"-д томилогдон бүлгийн төлөвлөлтийн болон мэдээлийн системийн багт үүрэг гүйцэтгэсэн. Мэдээлэл технологийн газартай хамтран харьяа гаалийн 19 газар, хороодод зорчигчийн эрүүл мэндийн тандалт, халдварт өвчний нөхцөл байдлын мэдээ болон хилийн хөдөлгөөний мэдээллийг хүлээн авах, эрүүл мэндийн байгууллагатай мэдээлэл солилцоход шаардлагатай албаны цахим хаягийг шинээр үүсгэж, quarantine.health@customs.gov.mn хаягаар мэдээллийг түргэн шуурхай солилцох нөхцлийг бүрдүүлсэн.<br>Хүрсэн үр дүн:<br>Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед авч хэрэгжүүлсэн дээрх зөвлөмж, чиглэлийг Гаалийн газар, хороодод хүргүүлж ажилласнаар улсын хил, гаалийн хяналтын бүсээр хүний олон улсын хөл хориот өвчин гараагүй. | | |
| 2 | Бараа, тээврийн хэрэгсэлд | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Шадар сайдын ажлын | 1.Улсын хилээр нэвтрүүлж буй хорио цээр, эрүүл | 1. Бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт шалгалт хийх | 2024.01.01<br>2024.12.10 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийсэн байдал | | алба болон Интерактив ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй "Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах" төслийн хүрээнд гаалийн хорио цээрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг цахимжуулах зорилгоор Гаалийн ерөнхий газрын даргын А/62 дугаар тушаалаар ажиллаж буй "ажлын хэсэг"-ийн бүрэлдэхүүнд ажиллаж, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын чиглэлээр тухай бүр нь мэдээлэл өгч ажиллаж байна.<br><br>2. Тайлангийн хугацаанд эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр зөрчил илрээгүй.<br><br>3.Улсын хилээр нэвтрүүлж буй тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтэд хяналт тавихад мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.<br><br>4. Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжээс дотоод зурвас 2 | ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах бараанд хийх эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хийх ажлыг зохион байгуулах, харьяа газар, хороодыг мэргэжлийн удирдлагаар хангаж хяналт тавих.<br><br>2.Бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт шалгалт хийх үйл ажиллагааг зохион байгуулалтын бүтцийн бусад нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагаатай уялдуулж ажиллана.<br><br>3.Хяналт, шалгалтын үйл ажиллагаа, тайлан мэдээнд дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх<br><br>4.Газар, хороодын ариутгалын | үйл ажиллагааг зохион байгуулалтын бүтцийн бусад нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагаатай уялдуулан ажиллаж, зохион байгуулалтын нэгжид **12** дотоод зурвас хүргүүлж, **19** дотоод зурвасыг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Харъяа газар, хороодод 21 албан бичгийг чиглэл тус бүрээр хүргэж, мэргэжлийн зөвлөгөө өгсөн.<br>2.Гаалийн хилээр нэвтрүүлсэн бараа, тээврийн хэрэгслэлд урьдчилан сэргийлэх болон зориулалтын халдваргүйжүүлэлт хийсэн мэдээнд дүн шинжилгээ хийж ажилласан.<br>3. Гаалийн газар, хороодын хорио цээрийн үйл ажиллагааны тайлан мэдээнд дүн шинжилгээ хийж, Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/676 дугаартай тушаалын дагуу хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын статтистик мэдээг /7 дугаар сар/ хүлээн авч, нэгтгэн, нэгдсэн мэдээг Статистик, дүн шинжилгээний хэлтэст тогтоосон хугацаанд хүргүүлж ажилласан.<br>4. Харьяа гаалийн газар хороодын халдваргүйжүүлэлтийн байгууламжийн судалгааг гаргаж, Хуулийн хэлтэс, Санхүү, хөрөнгө оруулалтын газартай хамтран ариутгал, халдваргүйжүүлэлтийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүлээн авч, хариуг дотоод зурвасаар хүргүүлж, эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт, шалгалтын үйл ажиллагааг дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагаатай уялдуулан ажилласан.<br><br>5.Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтад хамрагддаг 483 /Их 61, дунд 284, бага 138/ нэр, төрлийн барааны БТКУС код дээр ажиллан 36 төрлийн барааны БТКУС-г хасуулснаар хяналтад хамрагдах барааг 7%-иар бууруулж, эрсдлийн анхааруулга /БТКУС нийт 211/ шалгуурыг бичиж, мэдээллийг ажлын хэсэгт илтгэлт оруулж хэлтсийн удирдлагад танилцуулсан. | байгууламжийн өнөөгийн судалгааг гаргах, холбогдох асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хамаарах чиг үүргийн нэгжтэй хамтран ажиллах<br><br>5.Гаалийн хилээр нэвтрүүлсэн бараа, тээврийн хэрэгслэлд урьдчилан сэргийлэх болон зориулалтын халдваргүйжүүлэлт хийсэн мэдээнд дүн шинжилгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангах<br><br>6. Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын үр дүнг сайжруулах зорилгоор холбогдох яам, агентлагаас зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэгт оролцох, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллах.<br>7. Харьяа гаалийн газар, хороодын улсын байцаагчдад | ажиллагааг хувийн хэвшилд шилжүүлэх асуудлыг судалж, төслийг боловсруулан Сангийн яаманд танилцуулсан.<br>5.Тээврийн хэрэгсэлийн халдваргүйжүүлэлт хийсэн мэдээнд дүн шинжилгээ хийхэд: улсын хилээр орсон **1386052** тээврийн хэрэгсэл (онгоц 5606, вагон 147209, суудлын машин 269062, ачааны машин 767615, автобус 196179, бусад 378)-д урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийх явцад хяналт тавьж ажилласан нь нондингийн мөн үетэй харьцуулахад **48** хувиар нэмэгдсэн байна.<br>Улсын хилээр гарсан **1099982** тээврийн хэрэгсэл (онгоц 5447, вагон зүтгүүр, суудлын вагон 44418, суудлын машин 270256, ачааны машин 754393, автобус 25466)-д хяналт тавьж ажилласан нь нондингийн мөн үетэй харьцуулахад **59** хувиар нэмэгдсэн байна<br>6.Бараа, тээврийн хэрэгсэлд тавих эрүүл ахуйн шалгалтын үр дүнг сайжруулах зорилгоор холбогдох яам, агентлагаас зохион байгуулсан 7 удаагийн уулзалт, 4 удаагийн хэлэлцүүлэгт оролцох, 2 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан.<br>7. Гаалийн ерөнхий газрын 2024 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Хилийн нэвтрэх цэг дэх ОУЭМД-ээр зохицуулагдах халдварт өвчний үеийн тандалт, хариу арга хэмжээ, халдварын сэргийлэлт, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сургалт зохион байгуулах. | хяналт” болон “Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал” сэдэвт 2 сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд нийт 56 гаалийн улсын /ахлах/ байцаагчд албан хаагч хамрагдсан. | | |
| 3 | Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын чиглэлээр дэд бүтцийг чадавхжуулсан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1.Хилийн автозамын Замын-Үүд боомтын зорчигчийн терминаль ашиглалтад орсонтой холбогдуулан шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, ариутгалын байгууламж, сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөөгөөр хангасан байна. | 1. Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт шалгалтыг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр санал боловсруулж хүргүүлэх<br><br>2.Алтанбулаг, Боршоо боомтуудад бараа, тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх байгууламж барих ажлын даалгаврыг боловсруулах | 1. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх "Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой худалдааны төсөл"-ийг хэрэгжүүлэх ажлын хэсгийн хуралдаанд 2024 оны 05 дугаар сарын 06-09 -ний өдрүүдэд оролцож, “BEST” төслийн хүрээнд Хавирга, Цагааннуур, Булган боомтын өргөтгөл, шинэчлэлийн төслийн асуудлаар хэлэлцэж, “Нэг-Эрүүл мэнд” бодлогын хүрээнд хийгдэх ажлын саналыг өгсөн.<br>2025 онд шинээр барьж байгуулах Бичигт хилийн боомтын холбогдох байгууламжуудын техникийн тодорхойлолтыг боловсруулан хүргүүлсэн.<br>Ховд аймгийн “Булган боомтын өргөтгөл шинэчлэл хийх” төслийн ажлын ээлжилт хуралдаанд оролцож, тухайн боомтод шинэчлэл хийхэд 4 хувилбарт бүтээн байгуулалтын санал, ОУЭМД-ийн дагуу нэвтрэн орох цэгт ноцтой байдлын үед боомтын бэлэн байдлыг хангах болон хорио цээрийн хяналт хийхэд зайлшгүй байршуулах шаардлагатай барилга байгууламж, талбай, техник тоног төхөөрөмжийн судалгааг | 2024.01.01<br>2024.12.10 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гаргаж, мэргэжлийн зөвлөмжийг өгсөн.<br>Завхан аймгийн Арц суурь, боомтын өргөтгөл, шинэчлэл, бүтээн байгуулалтын ажлын зураг төслийг гүйцэтгэж буй “Дукат” ХХК-иас ирүүлсэн зураг төслийг уялдуулан судалж, 4 саналыг нэмж тусгуулахаар хүргүүлсэн.<br>Боомтын сэргэлтийн үндэсний хорооны ээлжит хуралд Булган боомт шинэчлэлт, төлөвлөлт болон Бичигт-Зүүн хатавч боомтын замын холболт /4 эгнээг 6 эгнээ болгох/, Сүмбэр-Рашаант боомтын гүүрэн байгууламжийн сэргээн засварлалт хийх асуудалд ОУЭМД-ийн дагуу хилийн нэвтрэн орох цэгт ноцтой байдлын үед боомтын бэлэн байдлыг хангах болон хорио цээрийн хяналт хийхэд зайлшгүй шаардлагатай барилга байгууламж, талбай, техник тоног төхөөрөмжийг үндэслэн төлөвлөх, байгаль орчны үнэлгээг хийлгэх /цэвэр, бохир усны систем/ зэрэг 2 саналыг дэвшүүлсэн.<br>Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Шивээ хүрэн-Сэхэ боомтын төсөл”-ийг хэрэгжүүлэгч “Нарийн сухайтын төмөр зам” ХХК-ийн бүтээн байгуулалтын ажлын зурагтай танилцаж, хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын асуудлаар 5 саналыг боловсруулж хүргүүлсэн.<br>Сэлэнгэ аймаг дахь ГГ-ын Алтанбулаг хилийн боомт, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Увс аймаг дах ГГ-ын Боршоо хилийн боомтуудад хорио цээрийн хяналтын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ашиглагдах халдваргүйжүүлэлтийн байгууламжийг барьж байгуулах ажлын төслийн танилцуулга боловсруулж, боомтуудын өнөөгийн нөхцөл / дэд бүтэц, эдэлбэр газар, байршил/ байдлын талаарх судалгааг Боомтын хөгжлийн хэлтэстэй хамтран хийж, Хилийн боомтын захиргааны ээлжит хурлууд танилцуулж, СХОГ, Хяналт бүрдүүлэлтийн газруудтай хамтран Сангийн яамны төсвийн санхүүжилтээр барьж байгуулах ажлыг шийдвэрлүүлж ажилласан. Тухайн ажлын хүрээнд тус хилийн боомтын ерөнхий төлөвлөгөөний зургийн дагуу боомтын нэвтрэн орох хэсэгт зорчигчийн болон ачаа тээврийн халдваргүйжүүлэлтийн байгууламжийг тус тусд нь барьж байгуулахаар байгууламжийн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэх нээлттэй тендертийн ажлын хэсэгт ажиллаж, холбогдох материалд “Халдваргүйжүүлэлтийн байгууламжийн техникийн тодорхойлолт” болон “Хилийн боомтын нэвтрэн орох цэгт автотээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын даалгавар"-ын төслийг боловсруулж, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллаж байна. Байгууламжийн барилга угсралтын явц 57 хувьтай явагдаж байна.<br>Харьяа гаалийн газар хороодын халдваргүйжүүлэлтийн байгууламжийн өнөөгийн судалгааг гаргаж, Хуулийн хэлтэс, Санхүү, хөрөнгө оруулалтын газартай хамтран ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажиллагааг хувийн хэвшилд шилжүүлэх асуудлыг судалж, төслийг боловсруулан Сангийн яаманд танилцуулаад байна.<br>Гаалийн газар, хороодын Хорио цээрийн албаны хяналт шалгалтын 2025-ны үйл ажиллагаанд шаардлагатай 4 байгууламж 35 нэрийн 346 ширхэг тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн 9,239,208,386.0 төгрөгийн ( есөн тэр бум, хоёр зуун гучин есөн сая, хоёр зуун найман, гурван зуун наян зургаа төгрөгийн) судалгааг гаргаж СХОГ-т хүргэсэн.<br>Сонголт Дизайн ХХК-наас 2024.09.30-ны өдрийн 443/24 дугаартай "Хяналтын төхөөрөмжийн мэдээлэл хүсэх тухай" албан бичгийн хүрээд тухайн байгууллагын хүсэлтийн дагуу Замын-Үүд Чөлөөт бүс дэх хил, гаалийн хяналтын үйл ажиллагаанд ашиглах барилга байгууламжийн ерөнхий | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төлөвлөгөөний зураг дээр мэргэжлийн чиг үүргийн дагуу мэдээлэл өгч, саналыг тусгуулсан. | | |
| 4. | Магадлан шинжилгээний үйл ажиллагаанд тавьсан хяналт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | Хорио цээрийн чиглэлээр лабораторийн шинжилгээний дүнг авч үзэхэд: Нийт<br>223690.7тн, 118.981.558 ширхэг, 700 хайрцаг бараанаас 16096 удаа 50916,6кг, 14597 ширхэг, 107.7л, барааг шинжилгээнд хамруулахад 87842 үзүүлэлтээр шаардлага хангаж, 206 үзүүлэлтээр шаардлага хангаагүй байна. | 1.Хяналтын чиглэл бүрээр лабораторийн шинжилгээнд хамрагдсан барааны тоо хэмжээ, үзүүлэлтийн тайланг авч нэгтгэхэд хяналт тавина.<br>2Лабораторийн шинжилгээний зэрэг дүн буюу шаардлага хангаагүй үзүүлэлтэд дүн шинжилгээ хийнэ.<br>Энэ чиглэлээр газар, хороодыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангана. | 1.Гаалийн газар, хороодын хорио цээрийн албанаас 7 хоног бүр лабораторийн шинжилгээний мэдээг авч, нэгтгүүлэн удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан байна.<br>2.2024 оны 3 дугаар улирлын байдлаар хорио цээрийн хяналтад хамрагдсан барааны лабораторийн шинжилгээний 52430,4 мян.тн, 17129835 ширхэг, 54 хайрцаг бараа бүтээгдэхүүнээс 18163 удаа 40,0 мян.кг бараа, бүтээгдэхүүн шинжилгээнд хамруулсан байна.<br>Нийт шинжилгээнд хамрагдсан бараа нь 90600 үзүүлэлтээр шаардлага хангаж, 184 үзүүлэлтээр шаардлага хангаагүй гарсан нь урьд оны мөн үеэс 27330 үзүүлэлтээр илүү байна. | 2024.01.01<br>2024.12.10 | 94 |
| 5 | Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтад хамрагддаг 483 /Их 61, дунд 284, бага 138/ нэр, төрлийн барааны БТКУС код дээр ажиллан 36 төрлийн барааны БТКУС-г хасуулснаар хяналтад хамрагдах барааг 7%-иар бууруулж, эрсдлийн анхааруулга /БТКУС нийт 211/ | 1.Хорио цээрийн хяналтад хамрагдах барааны эрсдэлийн шалгуурыг боловсруулж эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж улаан төлөвт шалгагдах барааны тоог бууруулах | 1. ГЕГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/115 дугаартай “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалын дагуу “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын хяналтын удирдлагын систем”-ийг гаалийн автоматжуулсан мэдээллийн системтэй уялдуулан хөгжүүлэх ажлын даалгавар гаргах, ажлын төлөвлөгөө боловсруулах, туршилт хийх, нэвтрүүлэх хүлээн авах ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу эрүүл ахуй | 2024.01.01<br>2024.12.10 | 91 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шалгуурыг бичиж ажлын хэсэгт танилцуулсан.<br>2. Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтад хамрагдах барааг шалгах хяналтын хуудсыг цахимжуулах ажил үе шаттайгаар хийгдэж байна | 2.Хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан дүн шинжилгээ хийж, эрсдэлийн шалгуурыг тодорхой болгох<br><br>3.Гаалийн эрсдэлийн нэгдсэн удирдлагын журмыг ЭУХ-тэй хамтран боловсруулж, эрсдэлийн шалгуурыг тодорхой болгоход санал өгөх | халдвар хамгааллын хяналтын чиглэлээр хамрагдах асуудлын хүрээнд "SPS системийн өгөгдөл солилцооны модулаар солилцох систем, байгууллагын мэдээлэл" -ийг хийж гүйцэтгэн ажлын хэсэгт хамтран, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын чиглэлээр барааны нэр төрөл тус бүрд "Хяналт, шалгалтын заавар" нийт 9 боловсруулан ажилласан.<br>2."Гаалийн хяналтад эрсдэлийн удирдлага хэрэгжүүлэх журам"-ын хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын чиглэлээр санал нэгдсэн.<br>3. Барилга хот байгуулалтын яамнаас ирүүлсэн 02/1154 дугаартай "Хамтран ажиллах тухай" албан бичгээр нийт 13 нэр төрөл барилгын материалыг хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохиролын хяналтад хамруулах шаардлагатай талаар ирүүлсэн хүсэлт, Монгол Улсын барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 117 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгээс гарсан шийдвэр /Монгол Улсын зах зээлд нийлүүлэгдэж байгаа импортын барилгын материалын чанарт ахиц гаргах, барилгын материалын хилийн хяналтыг сайжруулах/; "Импортын барилгын материалын стандарт" хэлэлцүүлгээс гарсан саналыг үндэслэн 13 нэр төрлийн барилгын дотоод заслын материалын нийт ачилтын 60 хувьд өндөр эрсдэлийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шалгуурт /бараанд болон бичиг баримтын шалгалт/ хамруулах талаар “эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт”-ийг боловсруулж, хүргүүлэн Cais системд өндөр эрсдэлтэйд бүртгүүлэн бүрэн шийдвэрлэсэн. | | |
| 6 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тухай бүрт нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх чиглэлд:<br>1.УИХын тогтоол, ерөнхийлөгчийн зарлиг, ЗГ-ын тогтоол, ЕС-ын захирамж, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл, ЗГ-ын албан даалгаврын биелэлтэд эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлтэй биелэлтийг гаргасан.<br>2.Хуулийн хэрэгжилтийг хяналтын чиглэлийн 4 хуулийн хүрээнд гаргасан. | 1. Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналттай холбоотой эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах<br>2.”Сангийн сайдын шийдвэр, өгсөн үүрэг даалгаврын биелэлт”, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт” зэрэг холбогдох тогтоол, шийдвэрийн хорио цээрийн хяналттай холбоотой заалтын 2024 оны эхний хагас жилийн тайланг гаргах<br>3. Гаалийн хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын | 1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалын 6 дугаар хавсралтын дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 2 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг төлөвлөн боловсруулж, хэлтсийн даргаар батлуулан, биелэлтийг ханган ажилласан.<br>2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалын 8 дугаар хавсралтын дагуу эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гарган “А” дүгнүүлж ажилласан.<br>3.Хорио цээрийн үйл ажиллагаатай хамааралтай Засгийн газрын хөтөлбөр болон бусад тогтоол, шийдвэр, биелэлт, хуулийн хэрэгжилтийг 2023 оны жилийн эцэс, 2024 оны эхний хагас жилийн байдлаар гаргаж, холбогдох газарт хүргэж ажилласан.<br>"Албан тушаалын тодорхойлолт боловсруулах мэдээлэл цуглуулах асуулгын хуудас"-аар Гаалийн ерөнхий газар болон харьяа газар хороодын эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын чиглэл хариуцсан гаалийн улсын байцаагч нараас | 2024.01.01<br>2024.12.10 | 97 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | чиглэлээр хөрш зэргэлдээ болон бусад улстай протокол, санамж бичиг байгуулах, санал өгч ажиллах | саналыг авч, дүн шинжилгээ хийн хорио цээрийн чиглэлийн ажлын байрны тодорхойлолт”-ын төслийг /нийт 4 АТТ/ боловсруулж, хэлтсийн удирдлагад танилцуулсан.<br>4. Сангийн сайдын шийдвэр, өгсөн үүрэг даалгаврын биелэлт”, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт” зэрэг холбогдох тогтоол, шийдвэрийн хорио цээрийн хяналттай холбоотой заалтын 2024 оны тайланг гаргаж, хэлтсийн удирдлагад танилцуулж ажилласан.<br>5. БНХАУ-ын Эрээн хотод 2024 оны 05 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Хилийн эрүүл ахуй, хорио цээрийн хамтын ажиллагааны протокол”-ын хэрэгжилтийн ажлын хэлэлцээнд ХЦХ-ээс 3 төлөөлөл, ЗӨСҮТ-ийн 2 төлөөллийн хамт оролцож, зоонозын халдварын хил дамнах эрсдэлээс сэргийлэх, хяналт тандалт хийх 2024-2027 оны төлөвлөгөөг БНХАУ-Хөх хотын Гаалийн газар, Өвчин судлалын төв, Эрээн гаалийн газар, ЗӨСҮТ-тэй хамтран батлав. | | |
| 7. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1.Гаалийн тухай хуульд эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын асуудлыг тусгуулах чиглэлээр санал хүргүүлсэн. | 1.Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын чиглэлээр “Хяналт шалгалтын заавар” боловсруулах | 1. Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/380 тоот тушаалын 2 дугаар хавсралтад эрүүл ахуй халдвар хамгааллын хяналт, шалгалтад ашиглагдах 8 бараа бүтээгдэхүүний батлагдсан зааврын дагуу | 2024.01.01<br>2024.12.10 | 91 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2. Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журмын төсөлд санал өгсөн.<br><br>3. Хуулийн хэлтсээс ирүүлсэн "Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд" санал ирүүлэх дотоод зурваст 8 санал бичиж хүргүүлсэн.<br><br>Хүний нөөцийн хэлтсийн 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 01-1.1/1646 дугаартай албан бичигт "Гаалийн улсын байцаагчийг гаалийн байгууллагын нэгж хооронд шилжүүлэн ажиллуулах журам"-ын төсөлтэй танилцаж санал хүргүүлсэн. | 2.ГЕГ-ын даргын 2019 оны 275 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ыг шинэчлэх саналыг боловсруулж, холбогдох газар, хэлтэст хүргүүлэх<br><br>3. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, боловсронгуй болгох чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах | боловсруулах зааврын нэр, төрлийн жагсаалтыг тусгуулж ажилласан.<br>2. ГЕГ-ын даргын 2019 оны 275 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ыг шинэчлэхэд 2 саналыг боловсруулж, холбогдох газар, хэлтэст хүргүүлсэн.<br>3.МХЕГ-ын даргын 2020 оны А/142 дугаар тушаалаар батлагдсан "Улсын хилийн боомт, гүний хяналтын бүсэд халдваргүйжүүлэлт хийх журам"-ыг шинэчлэн ГЕГ-ын даргаар батлуулах төслийг боловсруулж, цаашид энэ үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, гаалийн байгууллагаас зөвхөн хяналт тавиулах эрх зүйн зохицуулалтыг бий болгохоор холбогдох газар, хэлтсийн удирдлагад танилцуулсан.<br>4.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай" хуульд 2 санал, "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай" хуульд 1 санал, "Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль"-д нэмэлт өөрчлөлт оруулах 1 санал тус тус өгсөн.<br>"Хилийн боомтод мөрдөх нийтлэг журам", Бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх заавар", Барааг буцаах, устгах заавар, "Бараанаас сорьц, дээж, загвар | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам"-д, "Импортлох, экспортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдалд хяналт тавих журамд"-ийн төсөлд 7 заалт бүхий саналыг боловсруулж хүргүүлсэн.<br>УОК-оос зохион байгуулсан Улаанбурхан өвчний тандалт сэргийлэлтийн шуурхай бүлгийн "Салбар хоорондын цахим систем"-ийн төслийн хэлэлцүүлэгт оролцож, Гаалийн байгууллагын үүрэг оролцооны талаар санал солилцсон.<br>Хүрсэн үр дүн:<br>Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангагдсан. | | |
| 8 | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Байгууллагын удирдлагуудаас /газрын дарга, дэд дарга, захиргааны удирдлагын газрын /өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хангаж ажилласан. | Өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж ажиллан тайлагнана. | Өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан.<br>1. Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудаас ирүүлсэн болон явсан дотоод зурвасыг архивын нэгж болгон бэлтгэн, архив хүлээлгэн өгсөн.<br>2. Шуурхай удирдлагын төвийн 1281 дугаарын лавлах утсанд хорио цээрийн хяналтын чиглэлээр түгээмэл ирдэг асуултанд мэдээлэл өгөх зааварчилгааг эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын чиглэлээр нийт 5 асуулт, хариултыг боловсруулж ажилласан.<br>3. ОНХА-тай хамтран гаалийн байгууллагын олон нийтийн цахимд "согтууруулах ундаанд | 2024.01.01<br>2024.12.10 | 67 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тавих хорио цээрийн хяналт", болон NTY телевизд "Барилгын материалын импортлоходт тавих хяналт" сэдвээр мэдээлэл өгсөн.<br>4. Удирдлагаас өгсөн үүргийн дагуу 2025 онд Гаалийн газар, хороодын Хорио цээрийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардагдах нийт 5 байгууламж, 35 нэрийн 417 ширхэг тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн 12,019,562,075.0 ( арван хоёр тэр бум, арван есөн сая, таван зуун жаран хоёр мянга, далан таван төгрөгийн) төсвийг гаргаж ажилласан.<br>5."Хилийн үр ашгийг нэмэгдүүлэхэд тогтвортой худалдаа төсөл"-ийн хүрээнд хэрэгжих Хавирга, Цагааннуур, Булган хилийн боомтын ерөнхий төлөвлөгөөний зурагтай танилцаж, тус боомтуудын өргөтгөл, шинэчлэлийн бүтээн байгуулалтад шаардлагатай нийт 3,572,026,000.0 (гурван тэр бум, таван зуун далан хоёр сая, хорин зургаан мянга) төгрөгийн үнэ бүхий 4 байгууламж 15 нэрийн тоног төхөөрөмж судалгаа, төсвийг гаргаж дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>Хүрсэн үр дүн:<br>Хугацаа хоцроосон үүрэг даалгаврын биелэлт байхгүй байна. | | |
| 9 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Ажлын цаг ашиглалтыг 100 хувь хангаан ажилласан. | Ажлын цаг ашиглалтыг сайжруулж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ. | Ажлын цаг ашиглалтыг сайжруулан, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэн ажилласан, өвчтэй, чөлөөтэй, тасалсан өдөр байхгүй. | 2024.01.01<br>2024.12.10 | 98 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Ажлын цаг ашиглалтыг 100 хувь хангана. | | | |
| 10 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1."ДЭМБ-ын аргачлалын дагуу хилийн боомт, гүний хяналтын бүсэд хүний олон улсын хөл хориот өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг авах, тандалтын чадавхийн үнэлгээг хийх" тухай удирдамжийг боловсруулахад санал өгч ажилласан.<br>2. ДЭМБ-ын ОУЭМД-ийн шаардлага хангасан чадавхийн гэрчилгээ авахад шаардлагатай холбогдох судалгааг Чингис Хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар дээр хийхэд судалгааны аргачлал боловсруулж байна. | ЗББНДБ болон харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагааны уялдаа холбоог удирдлага арга зүйгээр хэрхэн хангаж ажиллах<br><br>Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, төрийн болон төрийн бус болон гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах | 1. МУЗГ, БСҮХороо, Хилийн боомтын захиргаа, МҮХАҮТ-тай хамтран зохион байгуулсан **"Боомтын сэргэлт үндэсний форум 2024"** үйл ажиллагаанд оролцсон.<br>2. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ажлын дэд хэсэгт ажилласан.<br>3. Боомтын сэргэлтийн Үндэсний хорооноос зохион байгуулсан Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Ховд аймгийн "Булган боомтын өргөтгөл шинэчлэл хийх" төслийн ажлын ээлжит хуралдаанд оролцож, мэргэжлийн чиг үүргийн хүрээнд саналыг өгч, ерөнхий төлөвлөгөөний зурагт тусгуулан ажилласан.<br>4. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/84 дүгээр тушаалаар байгуулагдсан "Импортлох, экспортлох согтууруулах ундааны чанар, аюулгүйн үзүүлэлтийн техникийн зохицуулалт"-ыг шинэчлэн боловсруулж батлуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан.<br>5. Хил дамнасан усны 5 цэгт хийх эрүүл ахуйн шинжилгээтэй хяналтын удирдамжийг боловсруулан Сэлэнгэ аймаг | 2024.01.01<br>2024.12.10 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дах “Хил дамнасан усанд хяналт шалгалт хийх тухай “албан бичгийг хүргүүлж, биелэлтийг нэгтгэн ажиллалаа.<br>6.Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын Номхон далайн баруун бүс (НДББ)-ээс Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД-2005)-ийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны хүрээнд “Кристалл дасгал сургуулилт” дасгал, сургуулилалт ”Вектороор дамжих халдварт өвчин”-ий чиглэлээр ЗӨСҮТ, ОБЕГ, Мал эмнэлгийн ерөнхий газар, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн нийт 20 гаруй мэргэжилтнүүдийн хамт оролцож, үнэлгээг хийсэн. | | |

**Нэг. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхлэсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | Төрийн албаны тухай хуулийн 29.1-д заасны дагуу өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж ажиллах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | ЭМЯ, ХӨСҮТ-өөс зохион байгуулж буй “Талбарын тархвар судлалын 2 сарын сургалтанд хамрагдсан.<br>-Гаалийн ерөнхий газрын дэргэдэх сургалтын төвийн “Гаалийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалт”-д 2 сарын курст суралцаж, дадлага хийн | Танхимаар болон цахим хэлбэрээр сургалтад хамрагдсан байна. | 1. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр ДГБ-ын зөвлөлүүдийн хамтарсан “Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөр (AEO)” -ийг сайжруулах, тогвортой болгох үндэсний семинарт оролцож сургагч багшийн гэрчилгээг гардан авсан.<br>2. ГЕГ-ын дэргэдэх сургалтын төвөөс зохион байгуулж байгаа “Анхан шатны чиглүүлэх | 2024.01.01<br>2024.12.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | амжилттай төгсөж, гаалийн хэргийн мэдлэгтэй болсон.<br>- ГЕГ-ын албан хаагчдын мэдлэгийн түвшин тогтоох шалгалтанд хамрагдаж В үнэлэгдсэн | | сургалтад хамрагдаж буй суралцагчидад батлагдсан хуваарийн дагуу 4 удаагийн хичээл орсон.<br>3. Төрийн албан зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” цахим сургалт 3 удаа хамрагдсан.<br>4. Байгууллагаас зохион байгуулсан мэдээллийн цагт сууж цаг үеийн мэдээллээр хангагдсан | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Ц.ОТГОНБОР / .......................... / 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

( Албан тушаал ) ( Нэр, гарын үсэг ) ( Огноо )

## ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Ц.ОТГОНБОРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Хорио цээрийн хэлтэс

### 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | 58 | 10 | 68 | |
| 2 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | 56 | 8 | 64 | |
| 3 | Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлсэн байдал | 56 | 8 | 64 | |
| **Зорилт 4.“Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх” арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1 | Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын чиглэлээр дэд бүтцийг чадавхжуулсан байдал | 57 | 10 | 67 | |
| 2 | Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт,шалгалт хийсэн байдал | 57 | 10 | 67 | |
| 3 | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангасан байдал | 57 | 10 | 67 | |
| 4 | Магадлан шинжилгээний үйл ажиллагаанд тавьсан хяналт | 56 | 10 | 66 | |
| 5 | Үүрэг даалгаврын биелэлт | 59 | 10 | 69 | |
| 6 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | 57 | 10 | 67 | |
| 7 | Ажлын цаг ашиглалт | 59 | 10 | 69 | |
| **Дундаж оноо:** | | | | 66,8 | |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-д заасны дагуу өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж ажиллах | 90% | 13,5 | |
| Дундаж оноо: | | | 13,5 | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1 | Хандлага, ёс зүй | 6 | |
| 2 | Дүн шинжилгээ хийх | 6 | |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 6 | |
| 4 | Хариуцлагатай байдал | 6 | |
| 5 | Ажлын цаг ашиглалт | 6 | |
| | **Дундаж оноо:** | **6** | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1 | Хандлага, ёс зүй | 7 |
| 2 | Багаар ажиллах | 7 |
| 3 | Харилцаа | 7 |
| | **Дундаж оноо: 7** | |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | 66,8 |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 13,5 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | **6** |
| 4 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ | 7 |

| | | |
|---|---|---|
| 5 | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| | **Нийт оноо =93**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | **93** |

***Үнэлгээ өгсөн:***

***Нэгжийн дарга:***
Хорио цээрийн хэлтсийн дарга ........................................ (Г.Батмөнх)

........................*(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***
Гаалийн улсын байцаагч ............................... (Ц.Отгонбор)

.......................*(огноо)*

***Үнэлгээг хянасан :***

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***
Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ........................... (Г.Энхтайван)

12/20. 2024 .......................*(огноо)*

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***
Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч .............................. (Ө.Тэгшээ)

2024.12.20 .....................*(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч:***
Гаалийн ерөнхий газрын дарга ............................. (Р.Отгонжаргал)

........................*(огноо)*